

## МОНГОЛЫН НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ СУДЛАХ АСУУДАЛД

### А.Жамбал

ШУА – ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн

**Өгүүллийн зорилго:** Энэхүү өгүүлэлд өнөөгийн Монголын нийгмийн цогцолбор өөрчлөлтийг манай эрдэмтэд судалж буй байдал, түүний зарим үр дүн, ер нь эл асуудлыг судлах онол, арга зүйн тухай авч үзэхийг оролдсон болно.

**Түлхүүр үг:** Нийгэм, нийгмийн өөрчлөлт, шинэтгэл, шинэчлэл, шилжилт, онол, арга зүй, үзэл баримтлал, олон эшт үзэл, мэргэжлийн бус судлагч.

Хүний нийгэм хэвийн оршиж хөгжихэд зайлашгүй шаардлагатай чухал хүчин зүйлийн нэг бол нийгэм өөрийгөө танин мэдэж ухамсарлах явдал мөн болно. Энэ нь тухайн нийгмийн туулж өнгөрүүлсэн түүх, түүний туршлага, сургамж, нийгмийн амьдралын одоо цагийн шинж, төлөв байдал, асуудал, зорилтыг тодорхой судалж нэгтгэн дүгнэх замаар хэрэгжинэ. Ийм зорилт ялангуяа нийгмийн амьдрал огцом, үндсээрээ өөрчлөгдөх үед, нийгэм нэг төлөв байдлаас өөр шинэ төлөв байдалд шилжих үед нэн чухлаар тавигддаг ажээ.

Бид өнөөдөр урьд өмнө нь тулгарч байгаагүй, бидэнд танил биш, бас төлөв байдал нь төдийлөн тодорхой биш, хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд аж төрж байна. Энэхүү нийгмийг илүү сайтар, үндэслэлтэйгээр танин мэдэх олон талын хэрэгцээ шаардлага бидэнд бий билээ. Тэр дагуу наандаж дараах зорилтууд тавигдаж байгаагийн нэгд нь, монголын нийгмийн өнөөгийн динамик өөрчлөлтийн үйл явц, тодорхой шинж, төлөв байдал, ерөнхий дүр төрхийг аль болохуйц бүрэн бүтэн, үнэн зөв илэрхийлсэн нийгмийн эмпирик баримтын зохих санг бүрдүүлэх, хоёрдугаарт, хамгийн гол нь түүний үндсэн дээр нийгмийн өөрчлөлтийг онолын түвшинд судлаж танин мэдэх, түүнд удирдамж болохуйц онол, арга зүйн баримтлалыг боловсруулах зайлашгүй хэрэгтэй болоод байна. Энэ нь нийгмийн ухааны холбогдох чиглэлүүдийн эрдэмтэн, судлагчдын хамтын судалгаа, оюун сэтгэлгээний нэгдсэн хүч хөдөлмөр ба багагүй хугацаа шаардах цогцолбор бөгөөд бэрхшээлтэй, нарийн зорилт болох нь тодорхой юм.

Нийгэм, түүний өөрчлөлтийг танин мэдэх онол, арга зүйн асуудлыг авч үзэхдээ юуны өмнө орчин үеийн шинжлэх ухааны танин мэдэхүйн онол, арга зүйд тулгаран тавигдаж буй асуудал, зорилтын талаар дараах зүйлийг цухац дурдах нь илүүдэхгүй болов уу.

Сонгодог бус шинжлэх ухааны дараагийн буюу (постнеклассическая наука) ХХ зууны 70–аад оноос хойшхи үеийн шинжлэх ухаан, түүний онол арга

зүйн хөгжлийн хандлагаас дараах гол үндэслэл, үзэл санаа урган гарч байгаа ажээ. Тэдгээр нь :

- шинжлэх ухааны танин мэдэхүй, түүний ололттой үр дүн бүхий онолын мэдлэг нь нэг талаас судлагдаж буй бодит байдалын (байгал, нийгэм) систем, зохион байгуулалтын түвшин ба тэдгээр нь хэр зэрэг нарийн нийлмэл, динамик шинжтэй байгаагаас, нөгөөтэйгүүр бодит байдлыг танин мэдэж буй субъектийн нийгэм-соёлын түвшин, боловсруулж эзэмшсэн онол, арга зүй, хэрэглэж буй арга, хэрэгсэл, баримталсан үнэлэмж, эрхэмлэл, зорилгоос шалтгаална;

- бодит байдалын хувьсал, ялангуяа нийгмийн өөрчлөлт нь дан шулуун, дэвшин дээшлэх чиг шугамтай байдаггүй, харин муруй шугам бүхий урагшлах хийгээд ухрах, хөгжин дэвших хийгээд уруудан доройтох чиг шугам хослосон шинжтэй;

- судлан буй объектийн талаархи зөвхөн нэг онол төдийгүй түүнийг өөр өөр аспект, талаас нь тусгасан хэд хэдэн онол үнэн зөв байж болно;

- тиймээс нэг үзэгдэл, үйл явцыг хэд хэдэн онол, арга зүйн үүднээс цогцолбороор хандаж судлаж болно гэсэн үзэл санаа юм (1,5). (Энэ талаар ном зүйн 2,3,4 – д заасан зохиол бүтээлүүдээс дэлгэрэнгүй үзнэ үү).

Эдгээр ерөнхий үндэслэл, үзэл санаа нийгмийн шинжлэх ухаанд ч хамааралтай бөгөөд онол, арга зүйн чухал ач холбогдолтой юм. Тиймээс тэдгээрийг 1990 оноос хойшхи монголын нийгмийн язгуур, цогцолбор өөрчлөлтийг судлахад онол, арга зүйн иш үндэс болгож баримтлах боломжтой гэж үзэж болно.

Асуудлыг авч үзэхдээ ер нь орчин үеийн нийгэм, тухайлбал монголын нийгмийн амьдралын одоогийн хамгийн гол шинж, чухал онцлог нь юу вэ гэсэн асуулт юуны өмнө тавигдаж байгаа юм. Тэр бол нийгмийн язгуур шинжтэй, өргөн хүрээг хамарсан эрч хурдацтай өөрчлөлт гэж урьдчилж хариулж болно.

XX зуун нь нийт хүн төрлөхтөний болоод дэлхийн туурга тусгаар олон орны нийгмийн амьдрал асар их өөрчлөгдөж шинэчлэгдсэн зуун болж өнгөрөв. Шинэ XXI зуунд нийгмийн өөрчлөлт, шинэчлэлт улам гүнзгийрч, эрч хурдтай, амьдралын бүх хүрээг хамарсан, чанарын цоо шинэ шатад гарах хандлага нэгэнт тодорхой, бодитой болсныг эрдэмтэд онцлон тэмдэглэж байна.

Даяршилын нөлөөгөөр монголын нийгэм ч энэхүү түгээмэл үйл явцын тойрогт татагдан орсны тод илрэл бол 1980–аад оны сүүлч үеэс эхэлсэн, эдүгээ гүнзгийрэн явагдаж буй нийгмийн язгуур өөрчлөлт юм. Манай оронд 1990 оноос хойш явагдаж буй нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдралын язгуур өөрчлөлтүүд нь мөн чанар, агуулга, зорилго, гарч буй үр дүн, тулгарч буй асуудал, бэрхшээлээрээ монголын нийгмийн түүхэнд тэр бүр тохиолдож байгаагүй шинэ, өвөрмөц онцлогтой, нэн ээдрээтэй түүхэн том үйл явц мөн болно. Тэдгээр өөрчлөлт нь эрс буюу хувьсгалт, аажим буюу хувьсалын шинж

хослосон, ер нь нийгэмд үүсэж гардаг бүх төрлийн, тухайлбал, бүтэцийн, нийгмийн үйл явцын, үүргийн ба сэдэлийн (мотивын) гүн гүнзгий өөрчлөлтүүд байгаа юм. Монголын нийгэм тийнхүү өөрчлөгдөхөд нийгэм–эдийн засаг, улс төр, үйлдвэрлэл-технологи, оюун санааны шалтгаан, хүчин зүйлс хоорондоо нягт уялдаж цогцолбороор нөлөөлж үйлчилснийг манай эрдэмтэд судлаж илэрхийлсээр байна.

1990 оны ардчилсан хувьсгал нь өмнөх үед монголын нийгэмд хуримтлагдсан нарийн эдрээтэй зөрчил, бэрхшээл, алдаа гажуудал, асуудлыг шийдвэрлэх, нийгмийг дэлхийн улс орнуудын замналын голлох хандлага, нийтлэг жишигийн дагуу өөрчилж шинэтгэх, тогтвортой хөгжлийн замд оруулах зорилго, чиг баримжаагаар хийгдсэн билээ. Түүнээс хойшхи хугацаанд ардчилсан хувьсгалын зорилтуудыг хэрэгжүүлэх талаар багагүй зүйл хийгдэж нийгэм, эдийн засаг, улс төр, соёл, оюун санааны хүрээнд чухал ололтууд бий болов. Гэвч энэ хугацаанд олсон ололт, амжилтаас дутуугүй хэмжээний бэрхшээл, асуудал, шинэ алдаа гажуудал гарч ирж нийгмийн урагшлах хөдөлгөөнд саад тотгор учирдуулсаар байна.

Нийгмийн хуучин социалист байгуулал нурж, үзэл санааны марксист чиг баримжаа, үнэт зүйл алга болсон хэрнээ тэдгээрийн оронд шинэ нийгэм, шинэ үнэт зүйл гүйцэд бүрэлдэн тогтож хараахан чадаагүй, хүсэж хүлээсэн үр дүнг өгөөгүй байна. Нийгмийг бүхэлд нь, цогцолбороор шинэтгэх, тэр дотор эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийг орон зай, цаг хугацааны хувьд зэрэгцүүлж хийх зорилт тавигдаж, тэдгээр нь ихээхэн ээдрээ бэрхшээлтэйгээр хэрэгжиж байна. Монголын нийгэм урьд өмнө тулгарч байгаагүй шинэ, ээдрээтэй нөхцөл байдал, нарийн төвөгтэй зорилтуудтай тулгарч байгаагийн дээр тэдгээрийг ямар арга хэрэгсэл, хэлбэрээр яаж шийдвэрлэх талаархи чиг баримжаа, төсөөлөл, үзэл баримтлал төдийлөн тодорхой бус байна. Ийм нөхцөлд нийгмийн шинжлэх ухаан, тэр дотор улс төрийн шинжлэх ухааны өмнө монголын нийгэмд одоо чухам ямар үйл явц явагдаж байна вэ, сонгож авсан зам, тавьж буй зорилт ба тэдгээрийн бодит биелэлт, хэрэгжилтийн хооронд ямар зөрөө, зөрчил, асуудал гарч байна вэ, тэдгээрийн шалтгаан, үндэс суурь нь юунд байна вэ, цаашдаа яах вэ гэх зэрэг онол-танин мэдэхүйн ба практикийн нэн чухал, хойшлуулашгүй асуудалууд тулгамдан тавигдаж судалгаа, боловсруулалтаа хүлээж байна.

Тийнхүү даяршиллын нөхцөлд хурдан өөрчлөгдөж, шинэчлэгдсээр байгаа монголын нийгэм нь XXI зууны эхэн үеийн нийгмийн танин мэдэхүй, түүний онол, арга зүйн судалгааны чухал объект болж байгаа юм. Энэ бол бидний авч үзэж буй асуудлын нэг тал нь юм.

Тэгвэл нийгмийн танин мэдэхүйн нөгөө тал болох нийгмийг шинжлэх онол, арга зүй, сэтгэлгээ өнөө үед ямар байдалтай, ямар түвшинд байна вэ ?

Шинжлэх ухааны онолын мэдлэг бол судлагдсан зүйл, объектын мөн чанар, шинж, төлөв байдлын тусгал бүхий санаалаг (идеалчилагдсан) загвар, илэрхийлэл байдаг. Өөрчлөгдөн буй, ялангуяа түргэн өөрчлөгдөн буй зүйлийг

судлаж танин мэдэх, нэгтгэн дүгнэсэн мэдлэг гаргаж авах нь тайван тогтвортой зүйлийг судлаж танин мэдэхээс илүү нарийн, бэрхшээлтэй ажээ. Танин мэдэхүйн энэ бэрхшээл түргэн өөрчлөгдөж буй орчин үеийн нийгмийг судлаж танин мэдэхэд бүр ч илүү, хурцаар тусаж байна. Үүнтэй уялдан манай орны нийгмийн ухааны өмнө онол, арга зүй, арга техник, зохион байгуулалтын шинэ чухал асуудал, нөхцөл байдал, зорилтууд тулгаран тавигдаж шийдлээ хүлээж байна.

Одоо үед ер нь нийгэм, тухайлбал нийгмийн байгуулал, тогтолцооны хувьд үндсээрээ өөрчлөгдөж чанарын өөр төлөв байдалд орсон монголын нийгэм ба түүнийг судлаж танин мэдэх онол, арга зүйн хооронд олон талтай зөрчил, үл тохирох байдал үүсээд байна. Нийгмийн тухай онолын мэдлэг, үзэл баримтлал, нийгмийг судлах арга зүй орчин үеийн нийгмийн амьдралын түргэн өөрчлөлтөөс хоцорч, тэдгээрийн хооронд багагүй зай завсар, зөрөө үүсэн гарчээ.

Эрдэмтдийн үзэж байгаагаар нийгэм, түүний өөрчлөлт, хөгжлийг авч үзэн ойлгож ирсэн уламжлалт онол, үзэл баримтлал, арга зүйн хандлагууд ХХ-XXI зууны зааг дээр нэг ёсондоо мухардалд орж, нийгмийн орчин үеийн шинж чанар, ялангуяа түүний динамик өөрчлөлтийг тэдгээр онол, арга зүйгээр авч үзэж танин мэдэх, тайлбарлан ойлгоход ээдрээ бэрхшээлтэй, өрөөсгөл талтай болжээ.

Ийм нөхцөлд нийгмийн танин мэдэхүйг тэрхүү мухардмал байдлаас гаргах, нийгмийн амьдралын одоогийн гүнзгий, хурдан өөрчлөлт ба түүний үр дүнд бий болж байгаа шинэ төлөв байдлыг танин мэдэж ойлгох бололцоо олгохуйц онол, арга зүйг боловсруулах зорилт зүй ёсоор тулгамдан тавигдаж байгаа юм. Эл зорилтыг хэрэгжүүлэх талаар нийгмийн онолын сэтгэлгээнд үндсэндээ гурван янзын чиглэлтэй оролдлого товойн гарсныг оросын нэрт социологич В.А.Ядов, польшийн социологич эрдэмтэн П.Штомпкагийн “Социология социальных изменений” гэсэн суурь бүтээлийн орос хэвлэлд зориулж бичсэн өмнөх үгтээ зааж тэмдэглэсэн байна (5,6).

Тэдгээр нь нэгдүгээрт, марксизм, хувьсалын онол (эволюционизм), бүтэцийн онол (структурализм) зэрэг сонгодог онолыг орчин үед нийцүүлж засварлан шинэчлэх, хоёрдугаарт, постмодернизмын философийн үзэл санааны дагуу нийгмийн олон янзын онол, үзэл баримтлалуудыг нийгмийн аль нэг үзэгдэл, үйл явцыг танин мэдэж ойлгоход хооронд нь холбож нэгтгэж хэрэглэх оролдлого, гуравдугаарт, орчин үеийн нийгмийн амьдралыг шинэ байдлаар үзэж ойлгох боломж олгохуйц шинэ онол, парадигм боловсруулах оролдлогууд ажээ (6,6). Эдгээр гурван чиглэлийн алинд нь ч нийгмийн өөрчлөлийг судлах онол, арга зүйн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж байгаа нь чухал байна.

Дээрхи чиглэлүүд бүхий онол, арга зүйн судалгааны үр дүнд нийгмийн өөрчлөлт (трансформаци), шинэтгэл, шинэчлэл, хувьсгал, хувьсал, шилжилт,

хөгжил, дэвшил, хямрал, зогсонги байдал, ухралт, уналт, бууралт гэх зэрэг хоорондоо багагүй ялгаатай боловч бас уялдаа холбоотой үзэгдэл, үйл явцуудын талаар шинэлэг, сонирхолтой үзэл баримтлал, дүгнэлтүүд дэвшигдэн тавигдсаар байна. Тэдгээрийн үр дүн, туршлагыг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх үндсэн дээр нийгмийн өөрчлөлтийг тусгайлан авч үзэж судладаг **нийгмийн өөрчлөлтийн социологи** хэмээх бие даасан салбар социологийн үндэс тавигдаж эхэлжээ (7).

Түүнчлэн нийгмийн нэг байгуулал, төлөв байдлаас өөр байгуулал, төлөв байдалд шилжиж байгаа нийгмийг тусгайлж судалдаг **транзитологи** (латин хэлний transitus- шилжилт, дамжин өнгөрөх гэсэн утгатай үгнээс гаралтай) хэмээх **нийгмийн шилжилт судлал** нь нийгэм судлалын хүрээнд бие дааж үүслээ хэмээн гадаадын зарим эрдэмтэд үзэх болов. Манай зарим эрдэмтэд ч тийм саналтай байна. Тухайлбал улс төр судлагч эрдэмтэн Ш.Содном “Өнөөдөр нийгмийн шилжилтийн үйл явцыг судалдаг транзитологи (шилжилт судлал) хэмээх мэдлэгийн тусгай салбар нэгэнт бий болсон байна. Транзитологи бол тоталитар болон авторитар дэглэмээс ардчилалд шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг судалдаг улс төрийн шинжлэх ухааны салбар юм” гэж бичжээ (8).

Орчин үеийн нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн үйл явцыг судлаж танин мэдэхэд хэрэглэж буй нийгмийн философи, социологи, улс төрийн онол, үзэл баримтлалуудын сан хөмрөг дотор модернизацийн онол зохих байр суурь эзэлж, эрдэмтэд түүнийг судалгаандаа хэрэглэж байгаа билээ. Модернизацийн онол нь нийгмийн шинэчлэлтийг өөрийн бие даасан судлагдахуун болгож авч үздэг бөгөөд тэгсэнээрээ шинэчлэлийн мөн чанар, зорилго, хэрэгжих арга зам, чиглэлийг тусгайлан судлаж танин мэдэх бололцоо олгодогт эл онолын ач холбогдол, онцлог оршино. Гэвч модернизацийн онолд хуучирсан, орчин үеийн нийгмийн бодит байдалд үл тохирох, бас үзэл сурталжсан, тиймээс ч эргэн харж дахин нягтлах, засварлаж өөрчлөх үзэл санаа, дүгнэлт, томъёолол цөөнгүй байгаа талаар эрдэмтэд тэмдэглэжээ (9).

Дэлхийн хэмжээний нийгэм судлалын онол, арга зүйд тулгарч буй дээр дурьдсантай ижил төсөөтэй нөхцөл байдал, асуудал, зорилтууд манай өнөөгийн нийгмийн сэтгэлгээнд ч нэгэн адил тулгаран тавигдаж байна. Одоо энэ талаар бидний авч үзэн буй асуудалтай холбогдох хэмжээгээр нь товч өгүүлье.

Монголын нийгэмд 1990 оноос хойш улс төрийн ардчилал, оюун санааны эрх чөлөө, олон ургальч үзэл хэрэгжих болсноор нийгмийн шинжлэх ухаан нь улс төр, үзэл суртлын дарамт, хяналтнаас чөлөөлөгдөж сэтгэлгээний урьдын хэвшмэл нэг загвар арилж, судлагч нийгмийн үзэгдэл, бодит байдлыг өөрийн сонгож баримталсан аль нэг онолын үзэл баримтлал, арга зүйн хандлагаар авч үзэж судлах эрх чөлөөтэй болов. Манай философич, социологч, улс төр судлагч эрдэмтэд монголын нийгмийн өөрчлөлтийн өнгөрсөн ба өнөөгийн асуудлуудыг шинэ сэтгэлгээгээр судлах, үүний тулд холбогдох онол, арга зүйг шинэчилж боловсруулах шаардлагатай бөгөөд нийгмийг дан ганц марксист онол, ялангуяа

түүнийг үндэслэгчдээс хойшхи үед бүрэлдэж ноёрхсон догматик, гажуудсан, үзэл сурталжсан марксист онол, арга зүйгээр тайлбарлаж ойлгох аргагүй гэдэг талаар байр суурь, санал ерөнхийдээ нийлж байна. Тэгэхдээ марксист онол, арга зүйд хандах тодорхой асуудлын талаар манай эрдэмтдийн дунд үндсэндээ хоёр янзын хандлага, байр суурь ажиглагдаж байгаа юм. Манай хэсэг эрдэмтэд марксизм, тэр дотор эхэн үеийн сонгодог, аутентик марксизм ч гэсэн өнөөгийн нийгмийг судлаж танин мэдэх онол, арга зүйн цэнэг, нөөц бололцоогоо шавхаж дуусгасан, эл сургаал орчин үед ерөөс тохирохгүй, “ажиллахгүй” болсон, тиймээс түүнээс бүрэн татгалзах хэрэгтэй хэмээн үзэж байгаа юм. Энэ бол бас л нэг төрлийн туйлшрал, өрөөсгөл хандлага гэж үзэх үндэслэл бий.

Манай өөр нэг хэсэг эрдэмтэд марксист онол, арга зүйг социализмын үеийн үзэл суртал, догматизмын гаж нөлөө, хуурамч “бүрхүүл”, “шороо тортогноос” арилгаж, бүтээлчээр хандаж ашиглаж чадвал тэрээр одоогийн нийгэм, түүний өөрчлөлтийг судлаж танин мэдэх зохих хэмжээний бололцоог өгч чадна, тиймээс марксист онол, арга зүйгээс ор тас татгалзах, түүнийг няцаах, үгүйсгэх оролдлого нь шинжлэх ухаанч арга зарчимд харш зүйл болно гэж үзэж байна. Ийм үзэл, байр суурийг философич эрдэмтэн Г.Сайнхишиг дараах байдлаар гарган тавьжээ. Тэрбээр, “К.Маркс бол орчин үеийн социологийн ухааныг үндэслэгчидийн нэг буюу социологийн нэг сонгодог онолыг бүтээсэн суутан гэдгийг Өрнөдийн социологийн ямар ч сурах бичгээс үзэж болно. Нөгөө талаас орчин үеийн социологид Марксын сургуулийг дагасан зөрчлийн онол гэдэг томоохон чиглэл, парадигм нэр хүндтэй хэвээр байна. Ийм учраас марксч социологийг Зөвлөлтийн коммунист үзэл суртлын үеийн марксч-ленинч социологитой адилтган ойлгох ёсгүй юм. Гэтэл манайд чухам ийм төөрөгдөл дэлгэрчээ. Нөгөө талаас Зөвлөлтийн марксч-ленинч социологид орчин үеийн дэлхийн социологийн түвшинд хүрсэн онолын боловсруулалт, арга зүй, аргачилал байсан гэдгийг зөвхөн юм мэдэхгүйн харгайгаар л үгүйсгэж болох билээ” гэж бичжээ (10, 9-10).

Манай эрдэмтэд монголын нийгмийн өөрчлөлтийг судлаж танин мэдэх онол, арга зүйг шинэчилж боловсруулах талаар судалгаа хийж, зарим үр дүнд хүрч байна. Тухайлбал нэг талаар өрнө ба дорнын нийгмийн сэтгэлгээ, нөгөө талаар өрнөдийн өөрийнх нь янз бүрийн онол, сургаал, арга зүйн хандлагуудыг хооронд нь холбож хослуулах, тэдгээрийн дундаас интеграл хувилбар бүхий онол, арга зүйг гаргаж хэрэглэхийг оролдсон зэрэг судалгаа хийгджээ. Нэг дэх чиглэлээр профессор Н.Хавх дорно дахины гүн ухааны уламжлалт сэтгэлгээ, арга зүй болох арга, билгийг өрнө дахины сонгодог гүн ухааны сэтгэлгээний онол, арга зүй болох диалектиктэй шүтэлцүүлэн барилдуулах замаар арга билгийн сэтгэлгээг практик хэрэглээнд дөхөм болгож, нэгэн хувилбарыг боловсруулж, судалгаандаа хэрэглэж байгаа билээ (11). Тэр нь нэлээд хийсвэрдүү, нийгмийн философийн ерөнхий онолын шинжтэй байгаа ч гэсэн монголын нийгмийн өнөөгийн өөрчлөлт, шинэчлэлтийг судлахад анхаарч үзвэл зохих арга зүйн зарим үзэл санаа, дүгнэлтийг агуулж байгаа юм.

Профессор Г.Чулуунбаатар XX – XXI зууны зааг дахь монголын нийгмийн түүхэн өөрчлөлт, шинэчлэлтийг нийгэм-эдийн засгийн формацийн онол ба соёл, иргэншлийн онолын солбилцол, хослолын үүднээс судлан шинжлэх онол, арга зүйн хувилбарыг боловсруулах, хэрэглэх талаар судалгаа хийж нэгэн сэдэвт бүтээл туурвижээ (12).

Профессор Ц.Гомбосүрэн нийгмийн танин мэдэхүүд онол, арга зүйн янз бүрийн чиглэл, хандлагыг зүй зохистой холбож хослуулах замаар нийгмийн философийн интеграль (нэгдгэгч) хувилбарыг боловсруулах чиглэлээр судалгаа хийж сонирхолтой бүтээл нийтлүүлсэн юм (13).

Профессор Д.Дашпүрэв (14), Ц.Ганболд (15), Ц.Уртнасан (16), Ц.Пүрэв (17), Ц.Цэцэнбилэг (18), О.Сарантуяа (19), Н.Эрдэнэтунгалаг (20) зэрэг эрдэмтэд монголын нийгмийн амьдралын үндсэн хүрээ салбар, тэдгээрийн аль нэг тодорхой үзэгдэл, үйл явцын өөрчлөлтийг үндсэндээ модернизацийн онолоор авч үзсэн ба тэгэхдээ эл онолыг монгол орны түүхэн онцлог, нөхцөл байдалд нийцүүлж бүтээлчээр хэрэглэхийг хичээсэн нь арга зүйн ач холбогдолтой байгаа юм. Тухайлбал Д.Дашпүрэв монголын нийгмийн өнөөгийн язгуур өөрчлөлтийн мөн чанар, агуулгыг бүрдүүлж буй улс төрийн ардчилал, оюун санааны олон ургальч ёс, чөлөөт зах зээл, өмчийн эзнийг солих үйл явц зэрэг амин чухал асуудлуудад хандах монгол оронд тохирсон онол, арга зүйн үзэл баримтлалыг боловсруулах ёстой гэж тэмдэглээд энэ талаар сонирхолтой үзэл бодолыг гарган тавьсан байна (21. 28-29).

Эрдэмтэн Д.Чулуунжав монголын нийгэм, түүний өнөөгийн өөрчлөлтийг судлах онол, арга зүйг гаднаас зээлдэж хуулбарлах, түүнд манай бодит амьдралыг санаагаар тохируулах гэж оролдох явдал олонтоо гардаг бөгөөд энэ нь онол, танин мэдэхүйн хувьд алдаа төөрөгдөлтэй, практикын хувьд сөрөг үр дагавартай, тиймээс судалгааны удирдамж болохуйц онол, арга зүйг монголын нийгмийн амьдралын бодит хөрснөөс ургуулан гаргаж боловсруулах шаардлагатайг бүтээлүүддээ байнга тэмдэглэж байгаа нь судалгааны арга зүйн чухал сануулга мөн болно (22).

Эдгээрээс үзэхэд манай эрдэмтэдээс монголын нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийг судлах онол, арга зүйг шинэчилж боловсруулах талаар хийж буй судалгааны чиглэлүүд нь нийгмийн философи, ерөнхий социологийн онол, арга зүйн асуудлаар гадаадын эрдэмтэдийн хийж буй судалгаа, боловсруулалтын голлох хандлага, чиглэлтэй үндсэндээ ойролцоо, төстэй байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь гадаадын эрдэмтэдийн хийсэн тэдгээр судалгааны туршлага, үр дүн, онол, арга зүйн баримтлалыг монголын нийгмийн язгуур өөрчлөлтийг судлахдаа анхааран авч үзэж бүтээлчээр хэрэглэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

Төв ба Зүүн Европын хуучин социалист байсан орнууд, ОХУ–д явагдаж буй нийгмийн язгуур, цогцолбор өөрчлөлт нь манай нийгмийн өөрчлөлтөөс багагүй ялгаатай, онцлогтой, бас зарим талын ижил төстэй шинжтэй байгаа

билээ. Тэдгээр орон дахь постсоциалист өөрчлөлт, шилжилт, шинэчлэлт нь нэг талаар цаг хугацааны эрхээр одоогоор гүнзгий судлагдаагүй, онол арга зүйн шаардлагатай түвшинд нэгтгэн дүгнэгдээгүй байгаа боловч нөгөөтэйгүүр эрдэмтэд тэдгээрийг эхнээс нь чухалчилж, анхааралтай судлан онол-танин мэдэхүйн ба арга зүйн ач холбогдолтой олон тооны ном бүтээл, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлжээ (23). Судлаачид тэдгээр бүтээлдээ тухайн орнууд дахь нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн бодит үйл явц, гарсан үр дүн, ололт, бэрхшээл, асуудал, төлөв байдлыг их хэмжээний баримт мэдээ, бусад хэрэглэгдэхүүнээр илэрхийлэн гаргаж тавихын зэрэгцээ тэдгээрийг онолын түвшинд нэгтгэж дүгнэх, судлаж боловсруулах үзэл баримтлал, арга зүйн асуудалд ч анхаарал хандуулж тодорхой үр дүнд хүрч байна. Энэ нь монголын нийгмийн өөрчлөлтийг судлах онол, арга зүйн баримтлалыг боловсруулахад чиг баримжаа, аналог буюу жишээ болохуйц ач холбогдолтой юм.

Өнөөдөр монголын нийгэмд явагдаж буй өөрчлөлт нь олон талтай, олон давхраатай, нарийн, гүнзгий шинжтэй, хэд хэдэн чиглэл, хандлага хослосон байдалтай байна. Тиймээс тэдгээрийг нийгмийн тухай аль нэг онол, судалгааны аль нэг арга зүйгээр дангаар нь судлаж танин мэдэхийг оролдох нь хүссэн үр дүнд төдийлөн хүргэхгүй. Иймд нийгмийн шинжлэх ухааны өнөөгийн сан хөмрөгт байгаа олон янзын онол, үзэл баримтлал, арга зүйн хандлагуудаас монголын нийгмийн бодит байдлыг судлахад аль илүү таарч тохирох, нийцэх хэр хэмжээгээр нь зөв зүйтэй сонгож хэрэглэх, бас хэд хэдэн онол, арга зүйг хооронд нь оновчтой холбон хослуулж хэрэглэх нь илүү үр дүнтэй байх боломжтой юм. Тэгэхдээ нийгмийн өөрчлөлтийн аль нэг үзэгдэл, үйл явцыг судлахдаа янз бүрийн онол, түүгээр ч үл барам үзэл санаа, дүгнэлт, хандлага нь хоорондоо зөрчилддөг онол, үзэл баримтлалуудыг механикаар, хэлбэрдүүлж, замбраагүй холбож хэрэглэх бүдүүлэг алдаа гаргахаас сэрэмжлэх ёстой.

Монголын нийгмийн өөрчлөлт, тэр дотор эдийн засгийн ба улс төрийн өөрчлөлтийг судлаж танин мэдэх онол, арга зүйн судалгааг идэвхжүүлэх нь манай орны нийгмийн шинжлэх ухааны хөгжлийн дотоод логикоос урган гарч буй өөрийнх нь зүй ёсны зорилт мөн болно. Үүний зэрэгцээ энэ асуудлыг өнөөгийн нөхцөлд чухал болгож хурцаар тавихад нөлөөлж буй хөндлөнгийн өөр зарим хүчин зүйл ч байгаа юм. Тэдгээрийн дотроос дараах зүйлийн талаар хэдэн өгүүлбэр тэмдэглэхийг хүсэж байна.

Манай оронд бодитой хэрэгжиж буй нийгмийн олон ургалч үзэл, туурвиж бүтээх эрх чөлөөний ачаар нийгмийн үзэгдэл, үйл явцыг мэргэжлийн эрдэмтэн судлагчдын зэрэгцээ өөр мэргэжлийн, хөндлөнгийн хүмүүс ч сонирхон авч үзэж, өөрийн санал, үзэл бодлоо илэрхийлсэн өгүүлэл, ном бүтээл нийтлүүлэх болов. Үүний үр дүнд нийгмийн амьдралыг янз бүрээр үзэж ойлгосон, олон янзын, сонирхолтой өгүүлэл, бүтээлүүд гарч байна. Гэвч тэдгээрийн ихэнх нь эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл биш, дэвшүүлж тавьсан асуулт, түүнд өгсөн хариу тайлбар, үндэслэгээ нь гэнэн, болхи, онол арга зүйн тодорхой тавил, чиг баримжаагүй зэрэг нийтлэг дутагдалтай байгаа юм.



Мэргэжлийн бус, “чөлөөт, бүтээлч судлаач” гэгдэх хүмүүс, түүнчлэн нийгмийн ухааны мэргэжилтэй сэхээтний зарим хэсэг, түүгээр ч үл барам эрдмийн зэрэг цолтой зарим хүн монгол орон, монголын нийгэм бол хорвоод хосгүй, өвөрмөц онцлогтой бөгөөд тиймээс түүнийг элдэв хийсвэр онол, арга зүй, энэ тэр гэхгүйгээр өөрийг нь өөрөөр нь авч үзэж тайлбарлах, монголыг монгол ухаанаар л судлах, ойлгох хэрэгтэй, барууны элдэв янзын онол, арга зүй монголын бодит байдлыг танин мэдэх түлхүүр, чиг баримжаа болохгүй гэх мэтийн утга агуулгатай зүйл хэлж, бичиж байна. Үүнийг нийгэм, улс төрийн асуудал сонирхдог хүмүүс, нийгмийн ухааныг судлан эзэмшиж буй оюутан суралцагчдын тодорхой хэсэг нь хүлээн авч дагадаг болж байгаа нь анхаарал татаж, санаа зовоож байна. Үүнтэй холбогдуулж нийгмийг судлаж танин мэдэхэд онол, судалгааны арга зүйн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар дараах зүйлийг товч, өнгөцхөн ч гэсэн дурьдах нь илүүдэхгүй болов уу.

Шинжлэх ухаан, тэр дотор нийгмийн шинжлэх ухааны салбарууд өөрийн тодорхой ойлголт, хэвшиж тогтсон нэр томъёо, бичлэгийн стиль, асуудлыг авч үзэх ерөнхий онол, арга зүйн хандлага, тэдгээрт тавигдах шалгуур, шаардлагуудтай билээ.Тэдгээрийг сайтар эзэмшин баримтлаж, бүтээлчээр хэрэглэж байж шинжлэх ухаанч бүтээл гаргана. Нөгөөтэйгүүр монголын нийгэм, түүний өнгөрсөн ба өнөөгийн амьдрал хичнээн ч өвөрмөц онцлогтой, түүхэн тодорхой шинжтэй байлаа ч гэсэн эцсийн дүндээ бусад орны нийгэмтэй төстэй, түгээмэл, нийтлэг шинж чанаруудтай юм. Учир нь монголын ард түмэн, монголын нийгэм бол нийт хүн төрөлхтөн, дэлхий дэх хүний нийгмийн нэг хэсэг нь билээ. Тиймээс монголын нийгмийн өөрчлөлт, тэр дотор эдийн засгийн ба улс төрийн өөрчлөлтийг шинжлэх ухааны зарчим, шаардлагуудын дагуу судлаж үнэн зөв танин мэдэхийн тулд нэг талаар тэдгээрийг түүхэн тодорхой, бодитой авч үзэж шинжлэх, нөгөөтэйгүүр холбогдох ерөнхий онол, арга зүйн хандлагад үндэслэж тулгуурлах зайлшгүй шаардлагатай болно.

Нийгмийн үзэгдэл, үйл явцыг шинжлэх ухаанчаар судлаж танин мэдэх нь өөрөө угаасаа ямар нэг онол, арга зүйг заавал шаардна. Юмс үзэгдлийн мөн чанарыг чухамдаа онолын түвшинд, арга зүйн зөв зүйтэй хандлага, тавилын үндсэн дээр л танин мэдэх боломжтой. Аль нэг онол бол бодит байдлын тодорхой үзэгдлийг судлаж хийсвэрлэлийн өндөр түвшинд танин мэдэж нэгтгэн дүгнэсний үр дүн болж боловсрогддог, системчлэгдсэн, нотлогдсон, харьцангуй үнэн зөв мэдлэгийн тогтолцоо байдаг. Судлаж буй үзэгдэл хичнээн шинэ, өвөрмөц онцлогтой, түүхэн тодорхой шинжтэй байлаа ч гэсэн түүнийг судлаж танин мэдэхдээ түүнтэй нэг төрлийн, нийтлэг төстэй үзэгдлүүдийн талаархи урьд өмнө нь боловсрогдсон онолын үзэл баримтлалыг иш үндэс болгох, өөрөөр хэлбэл өмнөх үеийн судалгааны үр дүнд тулгуурлах, түүний туршлага, сургамжийг тооцож анхаарах шаардлагатай болно. Тодорхой онолын үзэл баримтлалгүй судалгаа бол эмпирик баримт, нэгж юмс үзэгдлийн явцуу хүрээн дотор эргэлдэхэд хүргэх ба зүйрлэж хэлбэл харанхуйд тэмтэчиж, юм юманд бүдрэхтэй адил болно.

Шинжлэх ухааны судалгаа, танин мэдэхүйд онолын нэгэн адил судалгааны арга зүй нэн чухал үүрэгтэй. Учир нь судалгаа, танин мэдэхүй нь өөрөө арга зүйн утга агуулгатай байдаг. Арга зүй нь тухайн үзэгдэлийг хэрхэн яаж хандаж авч үзэх вэ гэдэг суурь зарчмыг зааж, судалгааны явц ба түүнд хэрэглэж буй арга, хэрэгсэлүүдийг зөв, зүй зохистой зохион байгуулах, хүссэн үр дүнд хүрэх боломж олгоно, танин мэдэхүйн явцыг өөрийн рефлексстэй, хяналттай, логик чиглэлтэй болгоно.

Судалгаанд баримтлах онол, арга зүй бэлээхэн байдаг, эсвэл судалгааны явцад өөрөө аяндаа тодорхой болдог зүйл биш юм. Тэдгээрийг зөв сонгож баримтлах, чадварлаг хэрэглэх нь өөрөө бэлтгэл, судалгаа, дадлага туршлага шаарддаг мэргэжлийн нарийн хөдөлмөр мөн. Зөв зүйтэй сонгож авсан онол, арга зүй нь тодорхой асуудлыг судлаж боловсруулах, шийдвэрлэх ерөнхий үндэс суурь, чиг баримжаа болж өгнө. Тиймээс онолын судалгаа, танин мэдэхүйн логик нь нэгж, тодорхой асуудлыг судлаж шийдвэрлэхийн тулд эхлээд онол, арга зүйн ерөнхий асуудлыг шийдвэрлэхийг зайлашгүй шаарддаг байна.

Нийгмийг танин мэдэхэд онол, арга зүйн гүйцэтгэх үүрэг, ач холбогдолыг чухалчилж хандахдаа түүнээс урган гарч болох өөр нэг зүйлийг бас байнга анхаарах хэрэгтэй. Тэр бол онол, үзэл баримтлалд нийгмийн бодит амьдралыг зохиомолоор тулган тохируулах, загварчлах, хоосон онолдохоос ямагт сэрэмжилж зайлсхийх явдал юм. Нийгэм, түүний өөрчлөлтийн тухай онол, судалгааны арга зүй хичнээн боловсронгуй, хөгжингүй, үндэслэлтэй байлаа ч гэсэн тэдгээрт ямар нэг дутагдал, түүхэн хязгаарлагдмал тал, хийсвэр загварчлал ямагт агуулагддаг учираас нийгмийн бодит байдал, олон талтай баялаг амьдралыг бүрэн бүтэн, үнэн зөв танин мэдэж илэрхийлэхийг хүссэн бидний хүсэл, хэрэгцээг хараахан бүрэн гүйцэд хангаж чадахгүй. Тиймээс тухайн онолын үзэл санаа, дүгнэлт, давуу тал, түүнчлэн судалгаанд сонгож авсан арга зүйн зарчим, үндэслэлийг нийгмийг танин мэдэхэд үр өгөөжтэй чухал хэрэгсэл, арга болгож зөв зүйтэй зохион байгуулж ашиглах явдал хамгийн гол зүйл болно.

### **Ишлэл, зүүлт**

1. Социальное знание и социальные изменения. Отв.ред. В.Г.Федотова. М., 2001
2. Степин В.С. Теоретическое знание (Структура, историческая эволюция) М., 2000
3. Философия и методология науки. Учеб. пособие для вузов. Под.ред. В.И.Купцова. М., 1996
4. Философия для аспирантов: Учебное пособие.- Ростов на Дону, 2002
5. Штомпка П.Социология социальных изменений. Перевод с англ. Под.ред. В.А.Ядова. – М., 1996
6. Мөн тэнд
7. Мөн зохиолыг үзнэ үү

8. Содном Ш. Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц. – Политологи. – 2002. №1.
9. Федотова В.Г. Неклассические модернизации и альтернативы модернизационной теории. – Вопросы философии. – 2002, №12
10. Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. Редактор Ц.Уртнасан. УБ., 2001
11. Хавх Н. Нийгмийн гүн ухаан. Хоёр дахь хэвлэл. УБ., 1997  
- Хавх Н. Монголчуудын соёл, иргэншлийн гүн ухаан. УБ., 1995
12. Чулуунбаатар Г. XX, XXI зууны зааг үеийн Монгол дахь иргэний нийгмийн төлөвшил, хөгжил (Улс төр-философийн шинжилгээ). УБ., 1999
13. Гомбосүрэн Ц. Нийгмийн философийн интеграль (нэгдгэгч) хувилбарыг боловсруулах эхлэл. УБ., 1999
14. Дашпүрэв Ц. Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд. УБ., 2005
15. Ганболд Ц. Монгол дахь улс төрийн модернизацийн зарим онцлог. – МУИС – ийн эрдэм шинжилгээний бичиг. 1997, №3 (127)
16. Нийгмийн шинэчлэл: амьдралын хэв маягийн өөрчлөлт. Редактор Ц.Уртнасан. УБ., 2001
17. Мөн тэнд
18. Цэцэнбилэг Ц. Проблемы модернизации монгольского общества. УБ., 2002
19. Сарантуяа О. Шилжилтийн үеийн боловсролын нийгмийн асуудал. УБ., 2005
20. Эрдэнэтунгалаг Н. Монголын нийгмийн оюун санааны модернизацийн шинж төлөв, хандлага. Гүн ухааны дэд докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 1999
21. Дашпүрэв Д. Монголын хөгжлийн философийн асуудлууд: туршлага, хэтийн төлөв.- Монголын философчдын симпозиум (Сэдэв: “Өнөөгийн монголын нийгмийн философийн асуудлууд”). УБ., 1995, 12–32 дахь талд
22. Чулуунжав Д. Монголын төрийн тогтолцоо, түүний хууль, эрхийн үндсүүд дэх дутагдал, согог, асуудлууд (1990-1999). УБ., 1999  
- Чулуунжав Д. Монгол Улсын Үндсэн хуулийн эрхийн анхаарал татсан зарим асуудал. УБ., 2000  
- Чулуунжав Д. Монголын нийгмийн өвөрмөц байдалд тохирох төрийн засаглалын зохистой хэлбэр, хэмжээ, бүтэц, үүргийн асуудалд. УБ., 2004
23. Социалист байсан орнууд дахь нийгмийн өөрчлөлт, шинэчлэлийн судалгааны тоймыг дараах ном бүтээлүүдээс үзнэ үү. Үүнд:  
- Левый поворот и левые партии в странах Центральной и Восточной Европы. М., 1998

- Процессы демократизации в Восточной Европе (Материалы международной научной конференции. 2–8 июля 1999г., г. Улан-Удэ). Улан – Удэ, 2000
- Социальные трансформации в России: теории, практики, сравнительный анализ. Под ред. В.А.Ядова. М., 2005

### **Some aspects for studying the social transformation in Mongolia**

Mongolian all social spheres have been changing very fast and dynamically under the influences of world globalization. It is necessary to study and further tendency, result and action of the transformations. This research demands well elaborated theory and methodology.

It is impossible to explain and know Mongolian present social radical transformation on the classical theories such as marxism, evolutionism, structuralism and lining theory. It looks on shortcoming to study for Mongolian social transformation by the modernization theory, transit logy, post-modernism and new theory such as conception of post-communist countries transformation.

In this article author would like to study Mongolian present social radical transformation firstly, conducting the sufficient fund for social facts that shows social lives in the spheres of transformation which defines the quantitative and qualitative aspects on that factors. Secondly, grounding the optimal idea and sufficient variant to study and conduct the social transformation in Mongolian that possible needs to compare the many theories and conceptual ideas and conclusion that express social transformation, also that based on the rational synthesize.